



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 60

Ховд

“Тогтвортой хөгжлийн боловсрол”
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд боловсролын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн “Тогтвортой хөгжлийн боловсрол” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн үр дүнг жил бүр аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

0000192



“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ” ОРОН НУТГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

“Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.1, 6.3 дахь заалтууд, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.7 заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 209 дүгээр тогтоолоор баталсан “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”, Аймгийн ИТХ-ын Хуралдааны 2016 оны 10 дугаар сарын 21-ний 04 дүгээр тогтоолоор баталсан “Ховд аймгийн Ногоон хөгжлийн хөтөлбөр”-ийн 4 дүгээр зорилт, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах нь “Тогтвортой хөгжлийн боловсрол” орон нутгийн дэд хөтөлбөрийг боловсруулах нийтлэг үндэслэл болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХУГАЦАА

2.1. Хөтөлбөрийн зорилго

Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжсэн олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэгийг хөгжүүлж, сургууль бүхлээрээ ажиллах арга, хандлагыг үйл ажиллагаанд нь нэвтрүүлнэ.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

Зорилт 1. Сургалтыг дэмжсэн үйл ажиллагаагаар дамжуулан сурагчдын оролцоонд тулгуурлаж, эцэг эх, иргэдэд тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах;

Зорилт 2. Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлээр бүх салбарын хамтын ажиллагааг уялдуулан сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх;

Зорилт 3. Тогтвортой хөгжлийн боловсролын мэдээллийг нэмэгдүүлэн, бүх нийтэд хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэх;

Зорилт 4. Тогтвортой хөгжлийн төлөөх сургуулиудын сүлжээг бий болгон сургууль цэцэрлэгүүдэд түгээн дэлгэрүүлэх.

2.3. Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.1. Суралцагчдад тогтвортой хөгжлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг баяжуулж, хэрэгжүүлэх;

3.1.2. Сайн дурын сурагчдын “Эко клуб”-уудын үйл ажиллагааг сайжруулах

3.1.3. Эко сургуулийн үйл ажиллагааг дэмжиж, байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хүүхэд залууст төлөвшүүлэх;

3.1.4. “Хоггүй- Ногоон Ховд аймаг” болох зорилтот бүтээлч ажил өрнүүлэх.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.1. Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Боловсрол, шинжлэх ухааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол -2” төсөлтэй хамтран ажиллах;

3.2.2. Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх /СБААХ/ замаар тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургуулиудыг хөгжүүлэх;

3.2.3. Тогтвортой хөгжлийн боловсролын арга хандлага, зан үйл, соёлыг төлөвшүүлэх, нийтэд түгээн дэлгэрүүлэх;

3.2.4 Сургалтын байгууллагуудын тогтвортой хөгжлийн санаачилгыг дэмжиж, олон талын оролцоо, манлайлал, хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх.

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3.1.Боловсролын салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг тогтвортой хөгжлийн боловсролын зарчимд нийцүүлэх;

3.3.2.Тогтвортой хөгжлийн төлөөх үйл хэрэгт сурагчдын манлайлал, идэвхтэй оролцоо, санаачилгыг хөхиүлэн дэмжих;

3.3.3. Хэвлэл мэдээллийн бүх төрлийн сувгаар нийгмийн хариуцлагыг төлөвшүүлэх зорилгоор тогтвортой хөгжил, ногоон эдийн засаг, ногоон ажлын байр, ногоон амьдралын хэв маяг, байгальд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээний талаарх мэдээллийг тогтмол түгээх;

3.3.4. Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах тогтолцоог бий болгох.

3.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.4.1. Бүх салбарын бодлого, хөтөлбөрт тусгасан тогтвортой хөгжлийн боловсролын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

3.4.2. Тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлэх ажлыг орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах;

3.4.3. Бүх нийтэд тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3.4.4 Олон нийтийн оролцоот эко сургууль, цэцэрлэгүүдийг бий болгох.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

4.1.1. Тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг, мэдээлэл сурталчилгаа сайжирна.

4.1.2. Сургуулийн анги танхимд хичээлийн агуулгаар эзэмшсэн мэдлэгээ сурагчид өөрсдийн бүтээлч үйл ажиллагаандаа үр өгөөжтэй ашиглах бодит боломж олгоно.

4.1.3. Сургуулиудын өөрсдийн санаачилга, орон нутгийн түвшний бүтцүүд, тэдгээрийн чиг үүрэг, хариуцлага, хамтран ажиллах механизм бүхий тогтолцоо бүрдэнэ.

4.1.4 Иргэдийн оролцоо нэмэгдэж, төрийн байгууллагаас гарах аливаа шийдвэр нь тогтвортой хөгжлийн боловсролын асуудлаар харилцан уялдаатай хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

4.1.5. Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг эзэмшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэдийн оролцоо, дэмжлэг сайжирна.

4.1.6. Сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхэд байгаль орчноо хамгаалах, байгалийн нөөцийг хэмнэлттэй хэрэглэх, түүх соёлын өв, үндэсний зан заншлыг дээдлэх мэдлэг, боловсролтой болж, зөв дадал, эерэг хандлага бүхий иргэн болж төлөвших нөхцөл бүрдэнэ.

4.1.7. Тогтвортой хөгжлийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх, тэдэнд нөлөөлөх, тэдний хандлагыг өөрчлөх, орон нутгийн байгаль орчны хөгжлийн болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ “Сургуульд суурилсан орон нутгийн хөгжлийн загвар”-т тулгуурлана.

4.1.8. Хүүхдэд ээлтэй аюулгүй цэвэр орчин бүрдэнэ.

4.1.9. ISO14001 стандартад суурилсан олон улсын Эко-сургууль хөтөлбөрт сургуулиудыг 100 хувь хамруулна.

4.1.10. Мөнххайрхан, Буянт, Жаргалант сумын 1, 2 дугаар сургууль тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургууль болно.

4.1.11. Үндэсний дэд хөтөлбөр амжилттай хэрэгжинэ.

4.2. Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө:

4.2.1. Иргэд өөрийн амьдрах орчноо сайжруулж, тэгш, хүртээмжтэй боловсрол эзэмших, амьжиргаагаа дээшлүүлэх чадвартай болно.

4.2.2. Иргэдийн тогтвортой хөгжлийн боловсрол дээшилснээр тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болно.

4.2.3. Эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд хор хөнөөлгүй, хэрэглээний зөв зохистой соёл бий болж, өртөг зардлын хэмнэлт гарна.

4.3. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Нийт төсөв /сая төгрөг/	Суурь түвшин	Үр дүнгийн үзүүлэлт			
				Хүрсэн түвшин			
				2021	2022	2023	2024
Зорилт-1: Сургалтыг дэмжсэн үйл ажиллагаагаар дамжуулан сурагчдын оролцоонд тулгуурлаж, эцэг эх, иргэдэд тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах							
1	Тогтвортой хөгжлийн боловсролын агуулга, арга зүй тусгагдах сургалтын хөтөлбөрийн тоо	15	38	72	106	140	173
2	Сурагчдын дунд зохион байгуулсан арга хэмжээний тоо	13	0	2	6	12	24
3	Тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр мэдээлэл дамжуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагын тоо	29	0	1	2	3	4
4	"Хоггүй-Ногоон Ховд" бүтээлч ажлын аянд оролцсон байгууллагын тоо	19	0	-	58	58	58
Зорилт -2: Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлээр бүх салбарын, хамтын ажиллагааг уялдуулан сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх							
1	Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага нэвтрүүлсэн сургуулийн тоо	8	0	4	8	16	25
2	Тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургуулийн тоо	30	0	4	4	-	-
3	Цэцэрлэг бүхлээрээ ажиллах арга хандлага нэвтрүүлсэн цэцэрлэгийн тоо	1.2	0	0	12	11	33
4	Салбаруудын хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	14.4	0	0	5	10	15
5	Байгууллагын бодлого, хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалыг тусган хэрэгжүүлж буй албан байгууллагын тоо	0	11	21	31	41	58
Зорилт- 3: Тогтвортой хөгжлийн боловсролын мэдээллийг нэмэгдүүлэн, бүх нийтэд хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэх							

1	Тогтвортой хөгжлийн боловсролын төрөлжсөн сургалтад хамрагдсан хүний тоо	3	415	620	825	1030	1235
2	"Тогтвортой хөгжлийн боловсрол-Ховд" page хуудасны гишүүдийн тоо	0	76	300	800	1200	2000
3	Цахим мэдээлэл, сурталчилгааны тоо	0	20	200	400	800	1000
4	Сайн дурын хүүхдийн эко клубийн тоо	3	10	10	15	20	25
5	Цахим группэд хандсан иргэдийн хандалтын тоо	0	76	200	300	500	800
6	Хэвлэл мэдээллийн бүх төрлийн сувгаар тогтвортой хөгжил, ногоон ажлын байр, байгальд ээлтэй хэрэглээний талаарх зорилтот нэвтрүүлгийн тоо	3	0	10	20	30	40
Зорилт-4: Тогтвортой хөгжлийн төлөөх сургуулиудын сүлжээг бий болгон сургууль цэцэрлэгүүдэд түгээн дэлгэрүүлэх							
1	ISO14001 стандартад суурилсан "Олон улсын Эко сургууль" хөтөлбөрт хамрагдсан сургуулийн тоо	5	11	14	16	20	25
2	Эко цэцэрлэгийн тоо	5	0	5	10	15	20
3	Олон улс, туршлага судалсан хүний тоо	0	0	-	2	3	5
4	Ногоон ажлын байрны тоо	5	0	4	8	12	16
5	Орон нутгийн туршлага судалсан багш, сурагч, удирдлагын тоо	6	30	Багш-10 Сурагч -10	Багш-25 Сурагч -25	Багш -50 Сурагч -50	Багш -100 Сурагч -100
6	Олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэгийн тоо	1	Сургууль13 Цэцэрлэг 6	Сургууль16 Цэцэрлэг10	Сургууль19 Цэцэрлэг14	Сургууль 22 Цэцэрлэг 19	Сургууль 24 Цэцэрлэг 23

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

5.1. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

5.1.2. Гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж

5.1.3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив

5.1.4. Бусад

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар санхүүжүүлэх үүргийг хүлээнэ.

6.2. Байгаль орчин аялал жуулчлал, Боловсролын газар хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангана.

6.3. Боловсролын салбар, нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргах үүрэг хүлээнэ.

6.4. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчид, иргэд, хүүхэд залуучуудад байгаль орчин, тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

7.1. Боловсролын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр тайлагнана.

7.2. Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцно.

7.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг Боловсролын газар хариуцаж, хэрэгжилтэд төрийн болон төрийн бус байгууллагаар хяналт үнэлгээ хийлгэнэ.

7.4 Цэцэрлэг, сургуулиуд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах төлөвлөлтийг нэгдсэн төлөвлөгөөндөө тусган Боловсролын газарт хагас жил, жилийн эцэст тайлагнана.

НАЙМ.ХАМРАХ ХҮРЭЭ

- Хүүхэд багачууд, иргэд, олон нийт
- Төрийн болон төрийн бус байгууллагууд
- Багш, мэргэжилтэн, албан хаагчид

**"ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ"- ОРОН НУТГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны үе шат /төсөв/ сая төгрөг/				Хамтран ажиллах байгууллага	Нийт төсөв /сая төгрөгөөр/
					2021	2022	2023	2024		
Зорилт-1 : Сургалтыг дэмжсэн үйл ажиллагаагаар дамжуулан сурагчдын оролцоонд тулгуурлаж, эцэг эх, иргэдэд тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах										
1	1.1 Суралцагчдад тогтвортой хөгжлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг баяжуулж, хэрэгжүүлэх	"Тогтвортой хөгжлийн боловсролын" агуулгыг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх	Мэдлэг ойлголт тасралтгүй эзэмшинэ.	Сургууль, цэцэрлэгийн багш удирдлага	*	*	*	*	Боловсролын газар	Улсын зардал
2		Агуулгын судалгаат хичээл аян -1	Тогтвортой хөгжлийн агуулгыг интеграцичлах агуулга илрүүлнэ.	Мөнххайрхан Буянт 1,2 дугаар сургууль	*	*	*	*	БГ, ТХБ-2 төслийн ОНТ33Б	ТХБ-2 төслийн санхүүжилт
3		Арга зүйн судалгаат хичээл аян -2	Багш нарын арга зүйг дээшилнэ.	Сургууль -24		7.5		7.5		15.0
4	1.2 Эко сургуулийн үйл ажиллагааг дэмжиж байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд зэлтэй амьдралын хэв маягийг хүүхэд залууст төлөвшүүлэх	Сурагчдын дунд "Тогтвортой хөгжлийн боловсролын форум" зохион байгуулах	Ололт амжилт, сургамжаа хэлэлцэнэ, бусдад сурталчилна.	Сургуулийн сурагчид, багш удирдлага цэцэрлэгийн багш, удирдлага		6.0	6.0		Жаргалант сумын 1,2 дугаар сургууль Буянт, Мөнххайрхан	12.0
5		Эко сургууль зорилтот нэвтрүүлэг	Туршлага түгээн дэлгэрүүлнэ.	Буянт, Жаргалант 1, 7 сургууль		1.0			Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага	1.0

6	1.3 Сайн дурын сурагчдын эко клубуудын үйл ажиллагааг сайжруулах	"Бид эко хүүхэд" зуслан сургалт	Хамтдаа туршлага солилцоно, суралцана.	Эко клубын 100 сурагчид		6.0	6.0		БГ, ТХБ-2 төслийн ОНТЗЗБ	12.0
7		Байгальд хамгаалахад бидний оролцоо бүтээлч аян	Эцэг эх иргэдэд нөлөөлөл үзүүлнэ	24 сургуулийн сурагчид		5.0			Сургууль Орон нутаг БГ	5.0
8		Эко клубын зөвлөлдөх уулзалт	Асуудал шийдлээ тодорхойлно			6.0		6.0		12.0
9	1.4 "Хөггүй- Ногоон Ховд"- аймаг болох зорилгот бүтээлч ажил өрнүүлэх	"Ногоон байгууллага" болзолт уралдаан	Орон нутгийн орчинд хувь нэмэр оруулна.	Сургууль -24 Цэцэрлэг 33		5.0	5.0	5.0	БОАЖГ, Мэргэжлийн хяналтын газар Орон нутгийн тамгын газар ДБХС	15.0
10		"Хог биш Мод тарья" аян	Ногоон байгууламж нэмэгдэнэ.	Сургууль цэцэрлэг	*	*	*	*	Мод үржүүлгийн газар	Дотоод нөөц
11		"Хог" шүүмжлэлт нэвтрүүлэг	Хөггүй цэмцгэр орчин бий болно.	Аж ахуй албан байгууллага иргэд		2.0	1.0	1.0	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага	4.0
76 сая төгрөг										
Зорилт 2: Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлээр бүх салбарын хамтын ажиллагааг уялдуулан сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх										
1	2.1 Тогтвортой хөгжлийн боловсрол -2" төсөлтэй хамтран ажиллах	Төсөлд хамрагдсан 4 сургуулийн үндсэн төсөлд орон нутгийн дэмжлэг үзүүлэх	Хамтын гэрээ биелэгдэнэ.	Жаргалант сумын 1, 2 дугаар сургууль, Буянт, Мөнххайрханы сургууль	30.0				Орон нутгийн хөгжлийн сан	30.0

2		Зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Арга зүй удирдлагаар хангагдана.		*	*	*	*	ОНТЗЗБ	дотоод нөөц
3	2.2 Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх замаар тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургуулиудын хөгжүүлэх	Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагад суралцаж нэвтрүүлэх	Арга зүй эзэмшинэ.		*	*	*	*	БГ, ТХБ-2 төслийн ОНТЗЗБ	Төслийн санхүүжилт
4	2.3 ТХБ-ын арга хандлага зан үйл соёлыг төлөвшүүлэх нийтэд түгээн дэлгэрүүлэх	СБААХ түгээх	Арга зүйд суралцана.	Прогресс, Мянгад, Дөргөн Мөст, Манхан, Цаст-Алтай, 3,6,7 дугаар сургууль		8.0			1,2 дугаар сургууль, Мөнхайрхан, Буянт	8.0
5	2.4 Сургалтын байгууллагуудын тогтвортой хөгжлийн санаачилгыг дэмжиж, олон талын оролцоо, манлайлал, хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх			Буянт, Мөнхайрхан, Жаргалант 1,2 дугаар цэцэрлэг		1.2				1.2
6		СБААХ түгээх	Арга зүйг нэвтрүүлнэ.	Дуут, Цэцэг, Эрдэнэбүрэн, Зэрэг, Чандмань, Дарви, Булган-1 МБЦС, Ховд, Алтай, Үенч		11.0			Прогресс, Мянгад, Дөргөн, Мөст, Манхан, Цаст-Алтай, 3,7,6 дугаар сургууль	11.0
7				Жаргалант сумын 3,4,5,6, 7,8,9,10,11,12, 13,14,15,16 дугаар цэцэрлэг			2.0		Буянт, Мөнхайрхан, Жаргалант 1, 2 дугаар цэцэрлэг	2.0

8				Мянгад, Дөргөн, Зэрэг, Дарви, Ховд, Манхан, Чандмань, Цэцэг, Мөст, Булган, Үенч, Алтай, Дуут, Манхан, Эрдэнэбүрэн				1.4	Жаргалант сумын 3,4,5,6,7,8,9, 10,11,12,13, 14,15,16 дугаар цэцэрлэг	1.4
53.6 сая төгрөг										
Зорилт 3. Тогтвортой хөгжлийн боловсролын мэдээллийг нэмэгдүүлэн, бүх нийтэд хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэх										
1	3.1 Боловсролын салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг тогтвортой хөгжлийн боловсролын зарчимд нийцүүлэх	2,4,5 жил ажиллаж буй багш нарын сургалтын хөтөлбөрт ТХБ агуулга тусгаж оруулах	Багш нарын арга зүйд суралцана.	Багш нар		*	*	*	БГ, Сургууль, Цэцэрлэг	Дотоод нөөц
2	3.3, 3.4 Хэвлэл мэдээллийн бүх төрлийн сувгаар нийгмийн хариуцлагыг төлөвшүүлэх зорилгоор мэдээллийг тогтмол түгээх	Эцэг эх, иргэдэд сургалт зохион байгуулах	ТХБ талаар мэдлэг ойлголтой болно.	Иргэд		1.0	1.0	1.0	БГ, НБТ, ХИС	3.0
3		Цахим хуудас ажиллуулах	Мэдээлэл олон хүнд хүрнэ.	Бүх хүмүүс		*	+	+	БГ, Сургууль, ОНТЗЗБ	Дотоод нөөц
4		Зорилтот теле нэвтрүүлэг	Ойлголт мэдээлэл шуурхай хүрнэ.	Иргэд, сурагчид		1.0	1.0	1.0	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага	3.0
5	3.2 Тогтвортой хөгжлийн төлөөх үйл хэрэгт сурагчдын манлайлал, идэвхтэй оролцоо, санаачилгыг хөхиүлэн дэмжих;	Эко клубын нийгмийн оролцоо, идэвх санаачилгыг урамшуулах	Туршлагаа түгээн дэлгэрүүлнэ.	Сурагчид		1.0	1.0	1.0	БГ, БОАЖГ Сургууль	3.0
9.0 сая төгрөг										
Зорилт 4. Тогтвортой хөгжлийн төлөөх сургуулиудын сүлжээг бий болгон сургууль цэцэрлэгүүдэд түгээн дэлгэрүүлэх										

1	4.1. Бүх салбарын бодлого, хөтөлбөрт тусгасан тогтвортой хөгжлийн боловсролын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах	Олон улсын туршлага судлуулах	Туршлага судална.	Мөнххайрхан Буянт, 1,2 дугаар сургууль		*			Байгаль орчин мэдээлэл сурталчилгааны төв /БОМСТ/	ТХБ-2 төслийн санхүүжилт
2		Байгууллагууд тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах	Нэгдсэн уялдаатай болно.	Сургууль цэцэрлэг	*	*	*	*	БГ, Орон нутгийн удирдлага	Дотоод нөөц
3	4.2. Тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлэх түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах	Багш, сурагч, удирдлагуудыг Сэлэнгэ, Хэнтий аймгуудад туршлага солилцох	Туршлага хуримтлуулна	Биологийн багш нар, сурагчид, удирдлага			6.0		БГ, Орон нутгийн удирдлага	6.0
4		Төрийн болон төрийн бус байгууллагуудтай түншлэл тогтоох	Хамтын ажиллагаа сайжирна.	Сургууль цэцэрлэг	*	*	*	*	БГ, Орон нутгийн удирдлага	Дотоод нөөц
5	4.3. Бүх нийтад тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	Олон улсын эко сургуулийн сургалтад хамруулах	ISO14001 стандартад суралцана.	Булган-1, МБЦС, Үенч, Алтай, Мест, Дарви,ХПТК			5.0		БГ, БОМСТ	5.0
6		Олон улсын эко цэцэрлэгийн сургалтад хамруулах		Жаргалант 14,7 15.6,13,Буянт, Үенч, Дарви цэцэрлэг			5.0			5.0
7	4.4. Олон нийтийн оролцоот эко сургууль, цэцэрлэгүүдийг бий болгох	Эко сургууль цэцэрлэгийн сүлжээг үүсгэх	Эко сургууль цэцэрлэгийг түгээнэ	Жаргалант- 1,2,3,4,9,10,11,12 ,5,8,16,Зэрэг, Мянгад			1.0		Жаргалант 14,15,7,13, 6,Буянт, Дарви Үенч,цэцэрлэг	1.0

8	Ногоон ажлын байр бүтээлч ажлын "Challenge"	Ногоон ажлын байрны тоо нэмэгдэнэ.	Төрийн байгууллагууд	2.5		2.5	БОАЖГ, Мэргэжлийн хяналтын газар Орон нутгийн тамгын газар	5.0
								22.0 сая төгрөг
Нийт		32 ажил		30.0	74.2	32.5	23.9	160.6

--oOo--